

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Зорилт түвшин, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	12
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5. Аудит хийсэн зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Н.ГАНБОЛД
ТАНАА

2020.03.13 № 06/809
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага


Геологийн судалгааны төв ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг захирал Н.Ганболд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн ажил гүйлгээг аккруэл сууриар, үнэн зөв бүртгэж байх, шинэчилсэн маягтыг нягтлан бодох бүртгэлд мөрдөж ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын захирал санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 03 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, компанийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөж, тус компанийн ерөнхий захирал Ц.Сугармаа, аудитор Г.Эрдэнэчимэг, аудиторын туслах Э.Сайнзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг тус компанид 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 27 тоот албан бичгээр ирүүлсэн болно.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Геологийн судалгааны төв ТӨҮГ нь үйл ажиллагааны зорилгоо “Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд региональ геологийн болон бүх төрлийн ашигт малтмалын иж бүрэн судалгаа хийх, мэргэшсэн геологич бэлтгэх” гэж тодорхойлжээ.

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Геологи, геофизик, геохимийн региональ судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх;
- Лабораторийн зарим шинжилгээг стандартын дагуу гүйцэтгэх;
- Хайгуулын өрөмдлөгийн ажил гүйцэтгэх;

Геологийн судалгааны төв ТӨҮГ нь Бүс нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих “Голлох ашигт малтмалын хэтийн төлвийн судалгаа-2017”, “Гео мэдээллийн сан 2019”, Хойд, Төв, Зүүн, Азийн гүний геологийн процесс ба металлогенийн төслийн хүрээнд хэрэгжих “5 Улсын” зэрэг 3 төсөл, хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Геологийн судалгааны төвийн захирал Н.Ганболд нар УУХҮЯ-2018/038 тоот, УУХҮЯ-2017/9 тоот, УУХҮЯ-2019/12 тоот гэрээнүүдийг хийж, нийт 27,047.1 сая төгрөгийн санхүүжилт авахаар тооцсон бөгөөд тайлант онд улсын төсвөөс 13,385.0 сая төгрөгийн санхүүжилт авч хайгуул эрэл, тандалт судалгааны ажлыг гүйцэтгэж байна.

Тус төвийн орлогын эх үүсвэр нь дээрх гурван төслийн хүрээнд улсын төсвөөс олгож байгаа төсөл хөтөлбөр, арга хэмжээнд зориулсан санхүүжилтын орлого бөгөөд ажлын гүйцэтгэлийг сар бүр Ашигт малтмал, газрын тосны Геологийн хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдэд гарган өгч, хяналт хийлгэн баталгаажуулж, түүнийг үндэслэн холбогдох зардлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын төсвөөс сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлдэг байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж үнэлсэн.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн борлуулалтын орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлж, материаллаг байдлын хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүнгээс 12,301.3 сая төгрөгөөр тооцож, 123.0 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшингийн тооцоололд өөрчлөлт ороогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Геологийн судалгааны төв ТӨҮГ нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,667.9 сая төгрөгөөр буюу 165.8 хувиар өсчээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	897.1	3,293.9	2,396.8
Авлага	162.9	201.8	38.9
Бараа материал	9.7	7.9	(1.8)
Үндсэн хөрөнгө	538.9	772.9	234.0
Нийт хөрөнгө	1,608.6	4,276.5	2,667.9
Өр төлбөр	198.3	431.7	233.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,410.3	3,844.9	2,434.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,608.6	4,276.6	2,668.0

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн 2,396.8 сая төгрөгөөр өссөн нь тайланд хугацаанд гүйцэтгэх геологийн ажлын гүйцэтгэл нэмэгдэж, түүнтэй холбогдуулан санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 38.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант жилд Геомэдээллийн сан төслийн гүйцэтгэлийн баталгаанд 72.4 сая төгрөг нэмж байршуулснаас шалтгаалжээ.

Мөн ажлын гүйцэтгэл нь дууссан “Астер” төслийн барьцаа хөрөнгийн 15.0 сая төгрөгөөр хасагдаж, өмнөх оны НӨАТ-ын буцаан авалтаар 16.2 сая төгрөгийн авлагатай байсныг тайлант жилийн НӨАТ-ын өглөгөөс суутган тооцсон, өмнөх онуудад үүссэн 2.3 сая төгрөгийн авлагыг барагдуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 234.0 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2018 оны 12 дугаар 20-ны өдрийн 601 тоот тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 337.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсантай холбоотой байна. ТӨБЗГ-ын 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 129, 77 дугаар тогтоолуудаар 44.2 сая төгрөгийн хөрөнгийг актлан данснаас хассан, тайлант онд байгуулсан 103.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн дүнгээр тус тус буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 233.4 сая төгрөгөөр өсчээ. Энэ нь 210.8 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, 15.5 сая төгрөгийн НӨАТ-ын өр, тайлант оны эцэст “Саруул сайн” ХХК-д геологийн ажлын хөлс болох 57.4 сая төгрөгийг шилжүүлсэн боловч нэр, данс зөрүүгээр банк буцаасантай холбоотойгоор өр төлбөр нэмэгдэж, өмнөх оны аж ахуйн нэгжийн албан татварын 40.7 сая төгрөгийн, сандвэчин барилгын үлдэгдэл 9.6 сая төгрөгийн өр, төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

2.9. Зорилт түвшин, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг ТӨБЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 601 тоот тогтоолоор орлогыг 9,248.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 12,301.3 сая төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөөг 133.0 хувиар биелүүлжээ.

Геологийн судалгааны төв ТӨҮГ нь 2019 онд геологийн сэдэвчилсэн судалгааны “Голлох ашигт малтмалын хэтийн төлвийн судалгаа”, “Хойд, төв, зүүн азийн гүний геологийн процесс ба металлогени” 5 улсын төсөл, “Геомэдээллийн сан-2019” гэсэн 3 төслийн ажлыг хэрэгжүүлж, 2019 оны бизнес төлөвлөгөөгөөр 9,248,3 сая төгрөгийн орлоготой, 9,102.4 сая төгрөгийн зардал гаргаж, 131.3 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 9731.0 км геологийн эрлийн маршрут, 20961.0 тууш метр хайгуулын өрөмдлөг хийж нийт 12,301.4 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 9,510.6 сая төгрөгийн зардал гаргаж, 2,502.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Тайлант жилд 12,301.3 сая төгрөгийн орлоготой, 9,510.6 сая төгрөгийг зарцуулж, нийт 2,790.7 сая төгрөгийн ашигтай ажилласан, төлөвлөгөөгөөр 131.2 сая төгрөгийн ашигтай ажиллахаас 2,502.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл тодорхойлж, 14 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 14.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллаагүй асуудалд албан шаардлага хүргүүлэх, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг өгсөн.

1. Өмнөх аудитаар тус байгууллагын удирдлагад 1993-2003 онуудад үүссэн нэр бүхий 7 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудтай холбоотой авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллах тухай зөвлөмж өгсөн боловч тайлант хугацаанд 2 иргэнтэй холбоотой 2.2 сая төгрөгийн авлагыг барагдуулж, 4.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус төв нь 1997 оны А/304 тоот тушаалаар “Геологийн судалагааны товчоо” Засгийн газрын 1997 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 132 дугаар тогтоолоор геологийн региональ судалгаа, эрлийн ажлын талаарх мэдээллийг мэргэшсэн байгууллагын хэмжээнд төрд бэлтгэн аж ахуйн тооцоон дээр ажиллах болж, Худалдаа, үйлдвэрийн сайдын 2000 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/29 тоот тушаалаар “Геологийн судалагааны төв” ТӨҮГ болсноор өдийг хүртэл Төрийн өмчит үйлдвэрийн газар гэж аж ахуйн тооцоон дээр ажиллаж иржээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3-т: **“өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн**

төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд” буюу Улсын төсөвт үйлдвэрийн газрын зарчмаар ажиллах гэж заасан байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3-т заасны дагуу төвийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг оновчтой болгох талаарх асуудлыг дараагийн аудитад анхаарал хандуулах болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тайлант хугацаанд өмнөө тавьсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой 8, худалдан авалт түүний гүйцэтгэлтэй холбоотой 9, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн талаар 6 нийт 23 мэдээллийг хугацаанд нь байршуулжээ.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг хэрэгжүүлж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс авах авлагыг барагдуулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон тодруулга, тэмдэглэлийг холбогдох хууль, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Албан томилолтоор явсан ажилтнуудад урьдчилж гарсан зардлаар бүртгэж, дараа тайлангаарх гүйцэтгэлийн зөрүүгээр 0.4 сая төгрөг зардлыг бууруулсан, худалдан авсан сэлбэг, засварын материалын НӨАТ-ыг бүртгэхдээ зардлыг бууруулсан, жирэмсэн болон хүүхдээ асарч байгаа эхийн тэтгэмжийн мөнгийг тооцооны дансаар дамжуулаагүй, НДШ-ийн өглөг дансанд бүртгэсэн 9.9 сая төгрөгийн Нягтлан бодох бүртгэлийн 10.3 сая төгрөгийн алдаа, зөрчил гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”, 14 дүгээр зүйлийн 14.2-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө” гэснийг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, заавар, журмыг мөрдөөгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээг аккрузал сууриар, үнэн зөв бүртгэж байх, санхүүгийн тайланг холбогдох заавар, журмын дагуу тайлагнаж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Анхан шатны баримтын хөтлөлттэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Санхүү, Эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 дугаар тушаалаар баталсан хүчингүй болсон анхан шатны маягтуудаар нягтлан бодох бүртгэл хөтөлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг тус тус зөрчиж байна.

3.2.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтуудыг хүчингүй болсон маягтуудаар хөтөлсөн байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-р заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Маягт, заавар батлах тухай"-ыг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	897,068,064.01	3,293,961,475.38
1.1.2	Дансны авлага	6,239,725.20	3,989,725.20
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	16,199,088.18	-
1.1.4	Бусад авлага	140,491,556.00	197,841,282.00
1.1.6	Бараа материал	9,770,521.98	7,903,327.26
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,069,768,955.37	3,503,695,809.84
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	364,151,837.76	598,203,561.90
1.2.2	Биет бус хөрөнгө	174,783,800.00	174,783,800.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	538,935,637.76	772,987,361.90
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,608,704,593.13	4,276,683,171.74
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	9,600,000.00	52,800,000.00
2.1.1.3	Татварын өр	40,740,995.56	225,842,106.20
2.1.1.4	НДШ-ийн өглөг		12,799.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	148,003,520.00	153,077,120.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	198,344,515.56	431,732,025.20
2.2	Өр төлбөрийн нийт дүн	198,344,515.56	431,732,025.20
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - Төрийн	979,226,789.06	979,226,789.06
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	154,598,986.59	154,598,986.59
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	39,589,627.18	39,589,627.18
2.3.9	Хуримтлагдсан ашиг алдагдал	236,944,674.74	2,671,535,743.71
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,410,360,077.57	3,844,951,146.54
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,608,704,593.13	4,276,683,171.74

4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөг/	
		2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,988,585,076.39	12,301,360,362.84
2	Борлуулалтын өртөг	5,033,124,981.47	8,969,341,691.07
3	Нийт ашиг (алдагдал)	955,460,094.92	3,332,018,671.77
5	Хүүний орлого	16,047,572.12	48,447,362.19
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(368,869,769.38)	(497,139,184.73)
12	Бусад зардал	(79,378,482.81)	(87,654,805.19)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(8,250,247.50)	(4,931,866.40)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	515,009,167.35	2,790,740,177.64
19	Орлогын татварын зардал	59,404,805.76	287,808,454.42
20	Татварын дараах ашиг (алдагдал)	455,604,361.59	2,502,931,723.22
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	455,604,361.59	2,502,931,723.22
24	Орлогын нийт дүн	455,604,361.59	2,502,931,723.22
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,623,533,946.50	13,385,009,659.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,508,922,198.00	13,357,855,248.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,166,625.00	9,856,411.00
	Бусад мөнгөн орлого	104,445,123.50	17,298,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,970,626,288.30	10,634,106,689.17
	Ажиллагчдад төлсөн	1,454,075,259.00	1,910,665,471.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	332,894,898.00	471,060,116.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	259,551,629.00	485,742,233.50
	Ашиглалтын зардалд төлсөн	34,930,212.07	65,188,545.16
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	228,716,100.00	425,139,760.00
	Хүүний төлбөрт төлсөн		120,000.00
	Татварын байгууллагад төлсөн	573,747,787.20	952,754,429.55
	Даатгалын төлбөрт төлсөн	2,227,770.00	2,434,374.00
	Бусад мөнгөн зарлага	3,084,482,633.03	6,321,001,759.96
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	652,907,658.20	2,750,902,969.83
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	16,747,572.12	48,447,362.19
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	700,000.00	
	Хүлээн авсан хүүний орлого	16,047,572.12	48,447,362.19
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	229,441,300.00	334,258,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	191,441,300.00	334,258,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	38,000,000.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(212,693,727.88)	(285,810,637.81)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	339,592.50	45,141,733.59
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		45,000,000.00
	Ханшийн зөрүү	339,592.50	141,733.59
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	38,695,200.00	113,340,654.24
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		45,000,000.00
	Төлсөн ногдол ашиг	38,695,200.00	68,340,654.24
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(38,355,607.50)	(68,198,920.65)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	401,858,322.82	2,396,893,411.37
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	495,209,741.19	897,068,064.01
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	897,068,064.01	3,293,961,475.38

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	979,226,789.06	17,815,186.59	61,406,293.85	(203,374,600.85)	855,073,668.65
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				23,410,114.00	23,410,114.00
3	Залруулсан үлдэгдэл	979,226,789.06	17,815,186.59	61,406,293.85	(179,964,486.85)	878,483,782.65
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				455,604,361.58	455,604,361.58
6	Өмчид гарсан өөрчлөлт		136,783,800.00	(21,816,666.67)		114,967,133.33
7	Зарласан ногдол ашиг				(38,695,200.00)	(38,695,200.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	979,226,789.06	154,598,986.59	39,589,627.18	236,944,674.73	1,410,360,077.56
11	Залруулсан үлдэгдэл	979,226,789.06	154,598,986.59	39,589,627.18	236,944,674.73	1,410,360,077.56
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				2,502,931,723.22	2,502,931,723.22
15	Зарласан ногдол ашиг				(68,340,654.24)	(68,340,654.24)
17	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	979,226,789.06	154,598,986.59	39,589,627.18	2,671,535,743.71	3,844,951,146.54

4.5. Аудит хийсэн зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх талбай	кв.км	17,150	9,731	(7,419.00)	56.7
Баганат өрөмдлөг	т.м	13410	20961	7,551.00	156.3
Нийт орлого	мян.төг	9,248,271.0	12,301,360.4	3,053,089.40	133.0
Геологи хайгуулын ажил	мян.төг	9,248,271.0	12,300,360.4	3,052,089.40	133.0
Өрөмдлөгийн ажил	мян.төг	-	-	-	0.0
Бусад орлого	мян.төг	-	1,000.0	1,000.00	0.0
Нийт зардал	мян.төг	9,102,418.9	9,510,620.2	408,201.30	104.5
Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	862,075.9	541,278.4	(320,797.50)	62.8
Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	145,852.1	2,790,740.2	2,644,888.10	1913.4
ААНОА Татвар	мян.төг	14,585.2	287,808.5	273,223.30	1973.3
Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	131,266.9	2,502,931.7	2,371,664.80	1906.8
Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	мян.төг	0.98	0.77	(0.21)	78.6
Нийт авлага	мян.төг	215,860.2	201,831.0	(14,029.20)	93.5
Нийт өглөг	мян.төг	149,413.7	427,165.7	277,752.0	285.8
Хөрөнгө оруулалт	мян.төг	339,040.0	337,378.0	(1,662.00)	99.5
Төрийн өмчийн ногдол ашгийн гүйцэтгэл, улс, орон нутгийн төсөвт өр төлбөргүй байх	мян.төг	1,647,880.3	2,217,144.0	569,263.70	134.5
Үүнээс: Ногдол ашиг	мян.төг	10,778.7	68,340.7	57,562.00	634.0
Нийт ажиллагсад	хүн	122	120	(17.00)	86.1
Цалингийн сан	мян.төг	2,085,853.6	1,850,645.5	(235,208.10)	88.7

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Геологийн судалгааны төв ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн</i>	Аудитын код:
2020			САГ-2020/17/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Геологийн судалгааны төв ТӨҮГ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог, нэр
	1	2	3	4	5
1	Албан томилолтоор явсан ажиллагсдын зардлыг урьдчилан шууд зардлаар бүртгэж, дараа тайлангаарх гүйцэтгэлийн зөрүүгээр зардлыг бууруулсан 435.1 мянган төгрөг, худалдан авсан сэлбэг, засварын материалын НӨАТ-ыг бүртгэхдээ зардлыг бууруулсан 7.5 мянган төгрөг, жирэмсэн болон хүүхдээ асарч байгаа эхийн тэтгэмжийн мөнгийг тооцооны дансаар дамжуулаагүй, НДШ-ийн өглөг дансанд бүртгэсэн 9,856.4 мянган төгрөгийн Нягтлан бодох бүртгэлийн 10,299.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил гарсан байна Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д заасан "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэснийг зөрчсөн байна.	10.3	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Н.Ганболд, Т.Батбилэг
2	Хүчингүй болсон Санхүү, Эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 тоот тушаалаар баталсан анхан шатны баримтуудаар нягтлан бодох бүртгэл хөтөлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг тус тус зөрчиж байна.	0.0	Зөвлөмж өгөх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Н.Ганболд, Т.Батбилэг
3	Өмнөх аудитаар тус байгууллагын удирдлагад 1993-2003 онуудад үүссэн нэр бүхий 7 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудтай холбоотой авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллах тухай зөвлөмж өгсөн боловч тайлант хугацаанд 2 иргэнтэй холбоотой 2.2 сая төгрөгийн авлагыг барагдуулж, 4.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	4.0	Албан шаардлага хүргүүлэх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Н.Ганболд, Т.Батбилэг
	Нийт	14.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 16 № 02/117
САГ-2020/17/СТЭ ТӨҮГ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн судалгааны төв ТӨҮГ-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар тус байгууллагын удирдлагад 1993-2003 онуудад үүссэн нэр бүхий 7 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудтай холбоотой авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллах тухай зөвлөмж өгсөн боловч тайлант хугацаанд 2 иргэнтэй холбоотой 2.2 сая төгрөгийн авлагыг барагдуулж, 4.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т: "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д: "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д: "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баримтжуулах ажлыг зохион байгуулах", тус төвийн захирал Н.Ганболд, ТӨБЗГ-ын дарга Б.Ганбат нарын хийсэн 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдөр хийсэн 2019-01 тоот гэрээний 3.2.2-т заасан ...Өр, авлагыг бууруулж ажиллах гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх аж ахуйн нэгж, байгууллагуудын 4.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг захирал Н.Ганболд, ерөнхий нягтлан бодогч Т.Батбилэг нарт даалгав.
2. Дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй байхад анхаарч холбогдох арга хэмжээ авч ажиллах.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Н. Ц. НАРАНЧИМЭГ
АУДИТОР
И. ЭРДЭНЭЦЭЦЭГ
"ТЭД-АУДИТ" ХХК-ИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ Ц. СУГАРМАА

ЗӨВШӨӨРСӨН:
ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ ТӨҮГ-
ЫН ЗАХИРАЛ
Н. ГАНБОЛД
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
Г. БАТБИЛЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

